ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗАР

ХҮНС ХӨДӨӨ АЖ
АХУЙ ЖИЖИГ ДУНД
ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

# "СҮҮ"
# ДЭД ХӨТӨЛБӨР



2011 он

# “Сүү” дэд хөтөлбөр /2011-2016он/

## Нэг. Нийтлэг үндэслэл, шаардлага

1. Сүү цагаан идээ нь хүний хоол боловсруулахад чухал үүрэгтэй кальци, уургаар баялаг байдгаас гадна найрлаганд нь хүний биеийн өсөлт, хөгжилтөнд хэрэгцээтэй 100 гаруй шимт бодис, нүүрс ус, уураг, өөх тос, эрдэс бодис, төрөл бүрийн витамин элбэг байдаг бөгөөд ходоодны хүчил шүлтлэгийг тэнцвэржүүлж өгдөг монголчуудын уламжлалт хүнсний нэг юм.

Тухайлбал сүүний 20 гаруй амин хүчлээс бүрддэг уураг нь хүний биеийн булчин шөрмөс болон дотоод эрхтний хэвийн үйл ажиллагаанд, сүүний тос витаминууд нь хүүхдийн өсөлт торнилтонд, бусад эрдэс, бичил махбод нь цус, ясны эд бүрэлдэх, мэдрэлийн системийн тогтолцоонд зайлшгүй шаардлагатай байдаг нь нэгэнт тогтоогдсон тул сүүний хангамж, боловсруулалт эрүүл ахуйн нөхцлийг сайжруулахад анхаарч 2006 онд Монгол Улсын Засгийн газраас “Сүү” үндэсний хөтөлбөрийг батлан гаргасан билээ.

Сүү, сүүн бүтээгдэхүүний хангамж, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах зорилгоор МУ-ын Засгийн газрын 2006 оны 239 тоот тогтоолоор батлагдсан “Сүү” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 2007 оны аймгийн Засаг даргын 383 тоот захирамжаар батлагдсан төлөвлөгөөг шинэчлэх, 2009 оны Засгийн Газрын хуралдаанаас УБ хотын хүн амын хэрэгцээнд нийлүүлэх сүүний үйлдвэрлэлтийг 2 дахин нэмэгдүүлэхээр өгсөн үүргийг хангах, ажлын байрыг нэмэгдүүлэх, хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан эрүүл хүнсний бүтээгдэхүүнээр хангах зорилгоор дэд хөтөлбөрийг боловсрууллаа.

## Хоёр. Сүү үйлдвэрлэлтийн өнөөгийн байдал:

Аймгийн мал сүргийн тоо 2010 оны эцэст 2710.7 мянган толгой болж хээлтэгч мал 1308.92 үүнээс ингэ 828, гүү 65019, үнээ 72976, эм хонь 681749, эм ямаа 488355 тоологдож 2009 оноос 15,94 буюу 239.84 мянгаар буурсан.

2010 онд ингэний 51.1, гүүний 45.9, үнээний 62.1, хонины 56.5, ямааны 48.5 хувь буюу 824.89 мянган хээлтэгч мал төллөж , 4824 үнээ саалинд хамрагдаж нийт 33.8 сая.л сүү үйлдвэрлэн 22.3 сая.л сүүг УБ хотын зах зээлд нийлүүлсэн. Судалгаанаас үзэхэд жилд дунджаар цэвэр болон эрлийзүнээнээс 2000 литр сүү, нутгийн үүлдэрийн үнээнээс жи лд дундажаар 540 литр сүү саараж байна.

Сүүлийн жилүүдэд эрчимжсэн аж ахуйн өндөр ашиг шимтэй цөөн тооны мал өсгөн үржүүлж мах, сүү үйлдвэрлэх иргэдийн сонирхол нэмэгдэж байна. Тухайлбал аймгийн хэмжээнд сүүний чиглэлийн фермерийн аж ахуйн тоо эрчимтэй өсөж 2008 онд 146, 2009 онд

181, 2010 онд 188 болж, эдгээрт хамрагдах саалийн үнээний тоо 8074 болж өмнөх оноос 130 толгойгоор нэмэгдсэн байна.

Манай аймгийн малчид, мал бүхий иргэд, байгууллага жилд дундажаар 38-41 сая литр сүү бэлтгэдэг бөгөөд аймгийнхаа сүүний хэрэгцээг бүрэн хангаад зах зээлд 19-22.3 сая.литр сүү нийлүүлж Улаанбаатар хотын сүүний хэрэгцээний 13.6 хувийг хангаж байна.

2011 онд нийт үнээний 72 хувь буюу 52542 үнээг саалинд хамруулан жилдээ 54813.0 мянган литр сүү үйлдвэрлэх боломж байгаа бөгөөд бусад малын сүүг уламжлалт аргаар сүү, цагаан идээгээ боловсруулан ааруул 24 тн, аарц 528 тн, ээзгий 4.6 тн,өрөм 1.2 тн-ыг тус тус бэлтгэж аймгийн хүн амын жилийн хэрэгцээнд 12.6 сая.л сүү, сүүн бүтээгдэхүүнийг ашиглаж үлдэх нөөцийг Улаанбаатар хотын зах зээлд нийлүүлснээр Засгийн газраас өгсөн үүргийг хангаж нийслэлд нийлүүлэх сүүний хэмжээг 2009 оныхоос 2 дахин нэмэгдүүлж **42.2 сая литрт** хүргэх боломжтой байна.

## Гурав . Хөтөлбөрийн зорилго, зорилт

3.1. Дэд хөтөлбөрийн зорилго нь МУ-ын Засгийн газраас өгсөн “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлж, үйл ажиллагаагаа өргөтгөх замаар Улаанбаатар хотын иргэдийн хэрэгцээнд нийлүүлэх сүү, сүүн бүтээгдэхүүний хэмжээг ойрын хоёр жилд 2 дахин нэмэгдүүлэх арга хэмжээ авах” гэж үүргийг ханган биелүүлж сүүний нөөцийг бүрэн ашиглаж, үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү, сүүн бүтээгдэхүүний хангамж, нэр төрлийг нэмэгдүүлэн сүүг **аймгийн брэнд** бүтээгдэхүүн болгоход оршино.

3.2. Хөтөлбөрийн зорилгын хүрээнд дараахь зорилтыг дэвшүүлж хэрэгжүүлнэ.

3.2.1. Тал хээрийн бүсийн сумдад уламжлалт аргаар цагаан идээг боловсруулж, эрчимжсэн мал аж ахуйг эрхлэх бүс нутаг болох Алтанбулаг, Аргалант, Батсүмбэр, Борнуур, Баянцогт,Баянчандмань, Жаргалант, Заамар, Лүн, Мөнгөнморьт, Сүмбэр, Угтаалцайдам, Эрдэнэ, Эрдэнэсант сумдад сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх, малчин өрх, фермер, үйлдвэр, цехүүдийг хоршин ажиллуулах нөхцөл боломжийг бүрдүүлэн малчдын орлогыг нэмэгдүүлнэ.

3.2.2. Сүү боловсруулах технологийг сайжруулах, үйлдвэр, цехүүдийн хүчин чадлыг бүрэн ашиглах замаар үйлдвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлж, сүү, сүүн бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн түвшинг сайжруулна.

3.2.3. Хүүхдийн хоол тэжээлийн хэрэгцээ, “Үдийн цай” хөтөлбөр, сургуулийн дотуур байр, эмнэлэгт хэвтэн эмчүүлэгсдийн хэрэгцээнд шаардлагатай зохицуулах үйлчилгээтэй баяжуулсан сүү, сүүн бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрлэлээр хангана.

3.2.4. Сүү цагаан идээний ач холбогдлын талаар сургалт, сурталчилгаа өрнүүлэн хэрэглээг нэмэгдүүлэх замаар үйлдвэрлэлийг дэмжинэ.

**Дөрөв. Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

4.1. “ Тал хээрийн бүсийн сумдад уламжлалт аргаар цагаан идээг боловсруулж, эрчимжсэн мал аж ахуйг эрхлэх бүс нутаг болох Алтанбулаг, Аргалант, Батсүмбэр, Борнуур, Баянцогт,Баянчандмань, Жаргалант, Заамар, Лүн, Мөнгөнморьт, Сүмбэр, Угтаалцайдам, Эрдэнэ, Эрдэнэсант сумдад сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх, малчин өрх, фермер, үйлдвэр, цехүүдийг хоршин ажиллуулах нөхцөл боломжийг бүрдүүлэн малчдын орлогыг нэмэгдүүлнэ.” зорилтын хүрээнд дор дурьдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.1.1. “Сүү” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх аймгийн төлөвлөгөөг шинэчлэн батлаж хэрэгжүүлнэ.

4.1.2. Тал хээрийн сумдын сүүний нөөцийг нэмэгдүүлэхийн тулд ямааны 50, хонины 20 хувийг саалинд бүрэн хамруулж, богийн сүүг ашиглан уламжлалт аргаар цагаан идээ үйлдвэрлэн зах зээлд борлуулах замаар иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ.

4.1.3. Алтанбулаг, Аргалант, Батсүмбэр, Борнуур, Баянцогт, Баянчандмань, Баяндэлгэр, Жаргалант, Заамар, Лүн, Мөнгөнморьт, Сүмбэр, Угтаалцайдам, Цээл, Эрдэнэ, Эрдэнэсант,Зуунмод сумдад сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуйг нэмэгдүүлэх болон өргөжүүлэн хөгжүүлэх, нэгжээс авах ашиг шимийг өсгөх замаар зах зээлд нийлүүлэх бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлнэ.

4.1.4. Сүү үйлдвэрлэх техник, технологи, эрүүл ахуйн нөхцлийг хангасан фермерийн аж ахуйн цогц орчинг бүрдүүлж, загвар фермерийн аж ахуйнууд бий болгохыг хөрөнгө оруулалт, зээлийн бодлогоор дэмжинэ.

4.1.5. Малын тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх чиглэлээр шүүст болон багсармал тэжээлийн үйлдвэр, цехыг Батсүмбэр, Баянцогт, Баянчандмань, Жаргалант, Сүмбэр, Угтаалцайдам, Цээл, Эрдэнэ, Эрдэнэсант сумдад шинээр байгуулна.

4.1.6. Фермерийн аж ахуйнуудад шаардлагатай тэжээлээ тариалах, үрээ нөөцлөхөд нь зориулж хэрэгцээт тариалангийн талбайг эзэмшүүлнэ.

4.1.7. Дарш, тэжээл бэлтгэн сүүний чиглэлийн фермерүүдэд үйлчлэх загвар дундын аж ахуйг Баянчандмань, Батсүмбэр, Борнуур, Жаргалант сумдад бий болгон хөгжүүлнэ.

4.1.8. Сумдын мал эмнэлэг, үржлийн тасгаар дамжуулан хээлтүүлэгчийг хянан баталгаажуулж, цөм сүрэг бүрдүүлэх, түүнээс өсвөр хээлтүүлэгч бойжуулан эдгээр малд үржлийн бүртгэл хөтөлж номержуулах ажлыг хэрэгжүүлнэ.

4.1.9. Бэлчээрийн даацанд тохирсон сүргийн бүтэц бүхий мал аж ахуйг хөгжүүлэх хээлтэгч хээлтүүлэгчийн зохистой тохироо бүрдүүлэх ажлыг зохион байгуулна.

4.1.10. Сүүний чиглэлийн фермерийн аж ахуйн үхрийн үржил шим, ашигт чанарыг нэмэгдүүлэх зорилгоор өндөр ашиг шимт үхрийн үр, хөврөл үрээр хээлтүүлэг хийх үйлчилгээ үзүүлэх, зохиомол хээлтүүлгийн пунктыг Аргалант, Баянцогт, Сүмбэр, Мөнгөнморьт сумдад шинээр байгуулж хамрагдах үнээний тоог өсгөнө.

4.1.11. Сүүний үхрийн үүлдэрлэг байдлыг хянах зорилгоор фермер бүрт үржлийн ажлын бүртгэл хөтлүүлдэг болгоно.

4.1.12. Үржлийн сайн чанарын өсвөр бух, гунж бойжуулах сүүний чиглэлийн үхрийн аж ахуйн нэгжүүд бий болгох замаар сүүний чиглэлийн фермерийн тоог 250-д хүргэнэ.

4.1.13. Тал хээрийн бүсийн Баян, Баянцагаан, Баян-Өнжүүл, Бүрэн, Дэлгэрхаан, Өндөрширээт, Сэргэлэн, Баянжаргалан, Архуст сумдад уламжлалт аргаар болон бага оврын тоног төхөөрөмж ашиглан цагаан идээ боловсруулна.

4.1.14. Малыг саалинд бүрэн хамруулахад малчид,бусад иргэд, хоршоод, нутгийн захиргааны байгууллагын ,үйл ажиллагааг уялдуулан чиглүүлж, саалийн оргил үед сүү үйлдвэрлэлт, бэлтгэн нийлүүлэлтийг нэгдсэн зохион байгуулалтанд оруулах арга хэмжээ авна.

**4.2. “**Сүү боловсруулах технологийг сайжруулах, үйлдвэр, цехүүдийн хүчин чадлыг бүрэн ашиглах замаар үйлдвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлж, сүү, сүүн бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн түвшинг сайжруулна” зорилтын хүрээнд дор дурьдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.2.1. Баянчандмань, Борнуур, Жаргалант, Сүмбэр, Мөнгөнморьт, Аргалант, Баянцогт, Лүн, Эрдэнэсант, Эрдэнэ сумдад сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах бага оврын үйлдвэр цехүүдийг хүчин чадлаар нь тогтвортой ажиллуулж, Батсүмбэр суманд хоногт 10 тн сүү үйлдвэрлэх хүчин чадал бүхий бүсийн хэмжээний сүүний үйлдвэр байгуулж бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлнэ.

4.2.2. Төв суурин газарт сүү нийлүүлдэг аж ахуйн нэгж болон фермерийн сүүнд тухай бүр шинжилгээ хийж, чанарын баталгаатай сүүг зах зээлд нийлүүлдэг болно.

4.2.3. Худалдаанд нийлүүлэх сүү, сүүн бүтээгдэхүүнийг чанар, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан нэр, хаяг, шошго бүхий сав, баглаа боодолтой болгоно.

4.2.3. Сүү сүүн бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, улмаар нийслэлд нийлүүлдэг сүүний хэмжээг нэмэгдүүлнэ.

4.2.4. Баянчандмань, Борнуур, Жаргалант, Сүмбэр, Батсүмбэр сумуудын сүү цуглуулж хөргөх танкир, хөргөлтийн төвүүдийн хүчин чадлыг нэмэгдүүлж, Аргалант, Батсүмбэр, Мөнгөнморьт сумдад 5-10 тны багтаамж бүхий хөргөх танкир, хөргөлтийн төвийг шинээр байгуулах замаар сүү боловсруулах үйлдвэрүүдийг түүхий эдээр хангах тогтолцоо бүрдүүлж түүхий сүүг гараас гарт дамжуулан элдэв хольц, бохирдолтой, эрүүл ахуй баталгаагүйгээр борлуулах үйл ажиллагааг хязгаарлана.

**4.3. “**Хүүхдийн хоол тэжээлийн хэрэгцээ, “Үдийн цай” хөтөлбөр, сургуулийн дотуур байр, эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгсдийн хэрэгцээнд шаардлагатай зохицуулах үйлчилгээтэй баяжуулсан сүү, сүүн бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрлэлээр хангана” зорилтын хүрээнд дор дурьдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.3.1. Хүүхдийн хоол тэжээл, сургуулийн Үдийн  цай” хөтөлбөр, эмнэлэг, сургууль, цэцэрлэгт гарал үүсэл нь тодорхой, баталгаатай сүү, сүүн бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэр, цехүүдээс нийлүүлэх замаар хүнсний хэрэглээнд сүү, сүүн бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлж үйлдвэрлэлийг дэмжинэ.

4.3.2. Суурин газар болон аялал жуулчлалыг түшиглэн сүү, цагаан идээний сувилал, цагаан хоолны цэг ажиллуулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

4.3.3. Зохицуулах үйлчилгээтэй сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн бий болгох, энэ талаар хөрөнгө оруулалт хийсэн байгууллага, иргэн, ААН-ийг урамшуулдаг болно.

4.3.4. Саалинд хамрагдаж байгаа эх мал, охин төлийг 100 хувь вакцинжуулж, бруцеллёз, сүрьеэ, лейкоз өвчний шинжилгээнд хамруулан  эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулна.

4.4. “Сүү цагаан идээний ач холбогдлын талаар сургалт, сурталчилгаа өрнүүлэн хэрэглээг нэмэгдүүлэх замаар үйлдвэрлэлийг дэмжинэ”зорилтын хүрээнд дор дурьдсан  үйл ажиллагааг хэрэгжүүлнэ

4.4.1. Сүү бэлтгэн нийлүүлэгчид, фермерүүдэд зориулсан технологийн  сургалтуудыг сүүний үйлдвэрлэл эрхлэгчтэй хамтран  жил бүр зохион байгуулна.

4.4.2. Өсвөр насны хүүхэд, залуучуудын өсөлт, хөгжил, эрүүл мэндэд сүү цагаан идээний шимт чанар, илчлэгийн ач холбогдолыг ойлгуулах сургалт, сурталчилгааг эрүүл мэнд, боловсролын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

4.4.3. Малын удмын сангийн үндэсний төвтэй хамтран зохиомол хээлтүүлгийн техникч нарыг чадавхижуулах, шинээр сургаж бэлтгэх ажлыг зохион байгуулна.

4.4.4. Өрх, хоршоо, малчдын бүлгийн түвшинд сүү боловсруулах бага хүчин чадалтай тоног төхөөрөмжүүдийг нийлүүлэх төслийг дэмжиж холбогдох аж ахуйн нэгж, иргэдтэй холбоо тогтооход нь зуучлах, уг тоног төхөөрөмжийг ашиглах сургалтуудыг үйлдвэрлэгчтэй хамтран зохион байгуулна.

4.4.5. Аж ахуйн нэгж, иргэдийг хамруулан жил бүр фермер аялал зохион байгуулж, шилдэг фермерүүдийн туршлагыг судлаж дэлгэрүүлнэ.

4.4.6. Сүү, цагаан идээ, саам сэдэвт аян, өдөрлөг, үзэсгэлэн худалдааг жил бүр зохион байгуулж олон нийтэд сурталчлана.

4.4.7. Хонь, ямааны сүүг ашиглан шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн боловсруулах, пакетлах боломжийн талаар шинжлэх ухааны байгууллагуудтай хамтран ажиллаж богийн үүс ний нөөц ашиглалтыг нэмэгдүүлэх талаар сургалт сурталчилгааг зохион байгуулна.

4.4.8. Хөтөлбөрийн үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр тодорхой ажил зохион байгуулж үр дүнд хүрсэн сумыг шалгаруулж урамшуулах журам гаргаж хэрэгжүүлнэ.

## Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

5.1. Аймгийн “Сүү” дэд хөтөлбөрийг 2011- 2016 онд хэрэгжүүлнэ.

## Зургаа. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гарах үр дүн

**6.**1. Сүү, сүүн бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, суурин болон хөдөөгийн хүн амын хэрэглээний ялгааг арилгаж УБ хотын хүн амын хэрэгцээнд нийлүүлэх сүүний хэмжээг 2011онд 42.2 сая /л–т хүргэж, цаашид нэмэгдүүлж хөтөлбөр дуусахад буюу 2016 онд 60.2 сая.литр сүү нийлүүлдэг болсон байна.

6.2. Сүүний чиглэлийн эрчимжсэн фермерийн аж ахуйн тоог 250 болгож үнээний тоог өсгөн 100 хувь саалинд хамруулдаг болсон байна.

6.3. Тал хээрийн сумдын төлтэй ямааны 50, хонины 20 хувийг тус тус саалинд ашигладаг болно.

6.4. Сүү цагаан идээний боловсруулалтын түвшинг дээшлүүлж, нийт бэлтгэсэн сүүний 20 хувийг үйлдвэрийн аргаар боловсруулдаг болсон байна.

6.5. Сүү цуглуулах, хөргөх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, борлуулах, тогтвортой бүтэц бий болно.

6.6. Мал бүхий иргэд, фермерүүдийн бэлтгэсэн сүүг хоршоогоор дамжуулан нэгдсэн журмаар баталгаатай сүүг хүлээн авч нийлүүлэх, нийлүүлсэн сүүнд нь урамшуулал олгодог биржийн тогтолцоог бий болгоно. Ингэснээр мэдээ тайланд бүрэн хамрагдана.

6.7. Малыг эрүүлжүүлэх ажлыг шат дараатайгаар авч хэрэгжүүлснээр малын бруцёллоз, лейкоз, сүрьеэ өвчний гаралт буурна.

6.8. Дарш болон шүүст тэжээлийн хэмжээ нэмэгдэнэ.

6.9. Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ өсөн  нэр төрөл олширч иргэд аюулгүй экологийн цэвэр бүтээгдэхүүнийг хүнсэндээ тогтвортой хэрэглэдэг болж хүн амын эрүүл мэндийн байдалд нааштай өөрчлөлт гарна.

6.10. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад фермерийн аж ахуйн болон  сүү боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр ажлын байрны тоо нэмэгдэнэ. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлснээр “Сүү сүүн бүтээгдэхүүний  үйлдвэрлэл” нь мал аж ахуй, газар тариалангийн дэд салбар болж хөгжих боломж нээгдэнэ.

## Долоо.  Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

7.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий Салбар зөвлөл ажиллана.

7.2. Салбар зөвлөл нь дараахь бүрэлдэхүүнтэй байна.

Салбар зөвлөлийн дарга: –Аймгийн Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: -ХХААЖДҮГазрын дарга

Гишүүд: -Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга

-Мэргэжлийн хяналтын газрын дарга

-Стандарчилал, хэмжилзүйн хэлтсийн дарга

-ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн ХХАА хариуцсан мэргэжилтэн

-ЭМГазрын дарга

-ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн хүнс, худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

хариуцсан мэргэжилтэн

-ХХААЖДҮГазрын Мал эмнэлгийн албаны дарга

-ХХААЖДҮГазрын Мал үржлийн албаны дарга

-ХХААЖДҮГазрын хүнс, худалдаа хариуцсан мэргэжилтэн

-Сумдын Засаг дарга нар

-ТББайгууллагын төлөөлөл

7.3. Суманд хөтөлбөр хэрэгжүүлэх зөвлөл ажиллах бөгөөд сумын Засаг дарга ахалж, гишүүдэд орон нутгийн төрийн албан хаагчид болон ТББ, ААНэгж, иргэдийн төлөөлөл орж ажиллана.

7.4. Хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөөг салбар зөвлөл болон сумын зөвлөлүүд тус тус боловсруулан батлуулж, хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүр тооцож ажиллана.

7.5. Хөтөлбөрт заагдсан зарим зорилт, чиг үүрэг, үйл ажиллагааг Шинжлэх ухааны болон ТББ-уудтай хамтран гүйцэтгэж болно.

7.6. Хөтөлбөрийн хэрэгжилтийн дүнг  жил бүр сумын Засаг дарга, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлаараа хэлэлцүүлж аймгийн салбар зөвлөлд ирүүлэх бөгөөд , аймгийн салбар зөвлөл аймгийн иргэдийнТөлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд өргөн мэдүүлж  дүгнэлт гаргуулна.

**Найм. Хөтөлбөрийн санхүүжилт**

8.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ.

8.1.1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын  өөрийн хөрөнгө

8.1.2.Орон нутгийн төсвийн хөрөнгө

8.1.3. “Аймаг хөгжүүлэх сан”, аймаг сумын “Мал хамгаалах сан”, “Сум үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэх сан” -аас олгох хөрөнгө

8.1.4.ЖДҮ-ийг дэмжих сангийн хөрөнгийн зохих  хувь

8.1.5.Төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх зориулалтаар улсын төсвөөс орон нутагт тусгагдсан хөрөнгө,тоног төхөөрөмжийн дэмжлэг

8.1.6.Харилцаат муж, олон улсын төслийн зээл, техник тоног төхөөрөмжийн болон буцалтгүй тусламж, хандивын  хөрөнгө

8.1.7.Бусад эх үүсвэр

8.2. Хөтөлбөр хэрэгжүүлэхэд төрөөс үзүүлэх дэмжлэгийг иргэн, аж ахуйн нэгжийн өөрийнх нь хөрөнгө оруулалттай хослуулан хөтөлбөрт заасан үр дүнд хүрэх хариуцлагын тогтолцоог бүрдүүлнэ.

**Ес .  Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт**

1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг дараахь шалгуур үзүүлэлтээр хэмжинэ.

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь түвшин 2010 он | Хөтөлбөр хэрэгжсэнээр хүрэх түвшин | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
| 1 | Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор баталсан эрхзүйн баримт бичиг, түүний хэрэгжилт | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | | | | | | | |
| 2 | Малын тэжээлийн үйлдвэрлэлтийн хэмжээ | мян.тн | 11.7 | 11.8 | 11.9 | 12.0 | 13 | 14 | 15.0 |
| 3. | Бэлтгэсэн даршны хэмжээ | тн | 7850 | | | | | | |
| 4. | Сүүний чиглэлийн фермерийн аж ахуйн тоо | | 188 | 195 | 200 | 215 | 230 | 240 | 250 |
| 5 | Цэвэр, эрлийз үнээний тоо | мян.тол | 16080 | 18110 | 20370 | 22680 | 25440 | 27590 | 29316 |
| 6 | Нутгийн үүлдрийн үнээний тоо | мян.тол | 28744 | 34432 | 36056 | 39076 | 42521 | 45822 | 47441 |
| 7 | Саалинд хамрагдсан бод малын тооны өсөлт /хувь/ | | 61.4% | 68.5% | 68.9% | 69.9% | 72.21% | 75.55% | 80.6% |
| 8 | Саалинд хамрагдсан бог малын тооны өсөлт /хувь/ | | 5% | | | | | | |
| 9 | Жилд бэлтгэх нийт сүүний хэмжээ | сая.л | 33.8 | 54.8 | 60.2 | 65.5 | 73.8 | 79.9 | 84.2 |
| 10 | Дотоодын хэрэгцээнд нийлүүлэх сүүний хэмжээ | сая.л | 12.3 | 12.6 | 14.1 | 14.3 | 14.8 | 14.9 | 15.0 |
| 11 | Зах зээлд нийлүүлэх сүүний хэмжээ | сая.л | 22.3 | 42.2 | 45.9 | 52.9 | 59 | 65 | 60.2 |
| 12 | Сүү цуглуулах цэгийн тоо | | 48 | | 49 | 50 | 52 | 54 | 55 |
| 13 | Сүү хөргөх цэгийн тоо | | 16 | | 17 | 18 | | 19 | 20 |
| 14 | Сүү боловсруулах үйлдвэр, цехийн тоо | | 13 | 14 | 15 | 16 | | 17 | 18 |
| 15 | Үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний хэмжээ | мян.тн | 3.2 | | | 5 | | | 20-30 |
| 16 | Нийт бэлтгэсэн сүүнд үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний эзлэх хувь | | 3% | | | 8.3% | | | 20% |
| 17 | Сүү,сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд оруулсан хөрөнгө оруулалт<br>1.Улсын төсөв | | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | | | | | | |
| | 2.Орон нутгийн төсөв | сая.төг | 50,0 | | | | | | |
| | 3.ЖДҮ-ийг дэмжих сан | сая.төг | 106.0 | | | | | | |
| | 4.Хөтөлбөр төслөөр | сая.төг | 242.0 | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 5.Иргэн, ААН-ийн өөрийн хөрөнгөөр | сая.төг | 160.0 | | | | | | |
| 18. | Шинээр бий болсон ажлын байрны тоо | | 36 | | | | | | |
| 19. | Сургалтанд хамрагдсан хүний тоо | | 156 | | | | | | |
| 20. | Нэг хүнд ноогдох сүү, сүүн бүтээгдэхүүний хэмжээ /сүүнд шилжүүлснээр /<br>1. Аймгийн төвд<br>2. Хөдөөд | литр<br>литр | 98<br>180 | | | 120<br>185 | | | 157<br>200 |

## ХҮН АМЫН СҮҮНИЙ ХЭРЭГЦЭЭНИЙ СУДАЛГАА /СУМДААР/

| № | Сумын нэр | Хүн амын тоо | Сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэгцээ | | Нийт хэрэгцээ мян.л |
|---|---|---|---|---|---|
| | | | Сэрүүний улиралд | Зуны улиралд | |
| | **Хоногийн хэрэгцээ норм** | | **350г/ 96.2 л** | **495г / 44.5л** | |
| 1. | Àëòàíáóëàã | 2918 | 293. 0 мян.л | 135.5 мян.л | **458.1** |
| 2. | Àðãàëàíò | 1585 | 189.0 | 87.3 | **248.8** |
| 3. | Àðõóñò | 1258 | 129.0 | 60.0 | **189.0** |
| 4. | Áàòñ¿ìáýð | 6753 | 618.0 | 286.0 | **904.0** |
| 5. | Áàÿí | 2011 | 199.3 | 92.2 | **292.0** |
| 6. | Áàÿíäýëãýð | 1292 | 112.0 | 52.0 | **164.0** |
| 7. | Áàÿíæàðãàëàí | 1575 | 154.3 | 71.3 | **225.6** |
| 8. | Áàÿí-ªíæ¿¿ë | 2103 | 224.0 | 103.4 | **327.4** |
| 9. | Áàÿíõàíãàé | 1427 | 139.0 | 64.2 | **203.2** |
| 10. | Áàÿíöàãààí | 1912 | 201.4 | 93.1 | **294.5** |
| 11. | Áàÿíöîãò | 1880 | 195.4 | 90.4 | **285.8** |
| 12. | Áàÿí÷àíäìàíü | 3730 | 365.0 | 169.0 | **534.0** |
| 13. | Áîðíóóð | 4817 | 450.0 | 208.0 | **658.0** |
| 14. | Á¿ðýí | 3024 | 294.0 | 136.0 | **430.0** |
| 15. | Äýëãýðõààí | 1677 | 185.0 | 85.4 | **270.4** |
| 16. | Æàðãàëàíò | 6223 | 575.0 | 266.1 | **841.1** |
| 17. | Çààìàð | 5084 | 566.0 | 262.0 | **828.0** |
| 18. | Ë¿í | 2604 | 239.0 | 111.0 | **350.0** |
| 19. | Ìºíãºíìîðüò | 2083 | 186.0 | 86.2 | **272.2** |
| 20. | ªíäºðøèðýýò | 1816 | 191.0 | 88.1 | **279.1** |
| 21. | Ñ¿ìáýð | 1708 | 164.0 | 76.0 | **240.0** |
| 22. | Ñýðãýëýí | 1983 | 182.0 | 84.2 | **266.2** |
| 23. | Óãòààë | 2411 | 219.0 | 101.2 | **320.2** |
| 24. | Öýýë | 2479 | 231.0 | 107.0 | **338.0** |
| 25. | Ýðäýíý | 3791 | 340.0 | 157.0 | **497.0** |
| 26. | Ýðäýíýñàíò | 4470 | 441.0 | 204.0 | **645.0** |
| 27. | Çóóíìîä | 15295 | 1468.3 | 679.0 | **2147.3** |
| | **Ä¯Í** | **87909** | **8477817л** | **5323896л** | **12656.0** |

## УЛААНБААТАР ХОТЫН СҮҮНИЙ ҮЙЛДВЭРҮҮДЭД НИЙЛҮҮЛДЭГ СҮҮНИЙ ХЭМЖЭЭ

| **Сүүний үйлдвэрийн нэр** | **Нийлүүлдэг сумдын нэр** | **Хэмжих нэгж /мян.л/** | **Жилд нийлүүлж байгаа хэмжээ** |
|---|---|---|---|
| СҮҮ ХХК | Батсүмбэр,Борнуур, Баянчандмань, Мөнгөнморьт, Жаргалант, Сүмбэр | мян.л | 14750.0 |
| МОН СҮҮ ХХК | Батсүмбэр | мян.л | 1500.0 |
| ЖОНОН ХХК | Эрдэнэ | мян.л | 500.0 |
| СҮҮН СОНДОР ХХК | Баянчандмань, Борнуур, Эрдэнэ | мян.л | 430.0 |
| ДАБЛЬ-ЭРДЭНЭ ХХК | Борнуур, Мөнгөнморьт,Эрдэнэ | мян.л | 550.0 |

Нийт Улаанбаатарт нийлүүлж буй сүүний 61,1% нь сүү боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлэгдэж байна.

## СААЛИЙН ҮНЭЭНИЙ АШИГ ШИМИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ДЭЭД ХЭМЖЭЭ

| Сумын нэр | ААН-ийн нэр | Үнээний үүлдэр, угсаа | Саалийн оргил үед өдөрт саасан сүүний хэмжээ / литр/ | Сард саах сүүний хэмжээ / литр/ | Жилд дунджаар саах сүүний хэмжээ /литр/ |
|---|---|---|---|---|---|
| Баянчандмань | Мон таримал ХХК | Хар тарлан | 32-35 | 1000-1005 | 9600 |

**Тайлбар: 2007 онд Хятад улсаас оруулж ирсэн сүүний чиглэлийн хар тарлан үнээний жилийн саам**

## ДАРШ БЭЛТГЭСЭН ААН, ИРГЭДИЙН СУДАЛГАА

| Д/д | Сумын нэр | ААН, иргэний нэр | Тариалсан талбай /га-аар/ | Бэлтгэсэн даршны хэмжээ / тн/ |
|---|---|---|---|---|
| 1. | Баянчандмань | 1.Мон таримал ХХК | 228 | 600 |
| | | 2.Чандмань милк ХХК | | 90 |
| | | 3.Агоро шунхлай ХХК | | 160 |
| | | 4.Иргэн Баярмаа | | 150 |
| | | 5. Иргэн Ганхүү | | 50 |
| | **Сумын дүн** | | **228** | **1050** |
| 2. | Борнуур | 1. Борнуур пүүдс | 150 | 238 |
| | | 2. Шинэ даваан булаг | 220 | 1430 |
| | | 3. Иргэд | 197 | 1280 |
| | **Сумын дүн** | | **567** | **2948** |
| 3. | Батсүмбэр | Агро-Альпа ХХК | 55 | 1200 |
| | | Лхам-Эрдэнэ ХХК | 40 | 200 |
| | | Иргэд | 410 | 2200 |
| | **Сумын дүн** | | **505** | **3600** |
| 4. | Жаргалант | Мөнх-Агьт | 73 | 75 |
| | | Иргэд | 139 | 177 |
| | **Сумын дүн** | | **212** | **252** |
| | **Нийт дүн** | | **1512** | **7850 тн** |

# СУМДЫН СҮҮНИЙ НӨӨЦИЙН СУДАЛГАА

| № | Сумын нэр | Нийт үнээний тоо /2010 оны жилийн эцсээр/ | Саалинд хамрагдах үнээний тоо | Үүнээс | | Жилд саах сүүний хэмжээ /мян.л / | | Нийт сүүний нөөц /литр/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Цэвэр, эрлийз үнээний тоо | Нутгийн үүлдрийн үнээний тоо | Цэвэр, эрлийз үнээний тоо /240 хоногт / | Нутгийн үүлдрийн үнээнээс 180 хоногт | |
| 1. | Алтанбулаг | 2988 | 2539 | 30 | 2509 | 75.0 | 1355.0 | 1430.0 |
| 2. | Аргалант | 1505 | 1279 | 310 | 969 | 775.0 | 523.2 | 1298.0 |
| 3 | Архуст | 593 | 504 | 18 | 486 | 45.0 | 262.4 | 307.0 |
| 4 | **Батсүмбэр** | **8365** | **7110** | **3250** | **3860** | **8125.0** | **5790.0** | **13915.0** |
| 5 | Баян | 797 | 677 | | 677 | | 365.5 | 365.5 |
| 6 | Баяндэлгэр | 2404 | 2043 | | 2043 | | 1103.2 | 1103.2 |
| 7 | Баянжаргалан | 1071 | 910 | | 910 | | 491.4 | 491.4 |
| 8 | Баян-Өнжүүл | 2338 | 1987 | | 1987 | | 1073.0 | 1073.0 |
| 9 | Баянхангай | 1398 | 1188 | 30 | 1158 | 75.0 | 625.3 | 700.0 |
| 10 | Баянцагаан | 944 | 802 | | 802 | | 433.08 | 433.08 |
| 11 | Баянцогт | 1993 | 1694 | 118 | 1576 | 295.0 | 851.04 | 1146.0 |
| 12 | **Баянчандмань** | **2601** | **2210** | **1810** | **400** | **4525.0** | **600.0** | **5125.0** |
| 13 | **Борнуур** | **4959** | **4215** | **1314** | **2901** | **3285.0** | **4351.5** | **7636.5** |
| 14 | Бүрэн | 2459 | 2090 | | 2090 | | 1128.6 | 1128.6 |
| 15 | Дэлгэрхаан | 1048 | 890 | | 890 | | 480.6 | 480.6 |
| 16 | **Жаргалант** | **4002** | **3401** | **276** | **3125** | **690.0** | **4687.5** | **5378.0** |
| 17 | Заамар | 3400 | 2890 | | 2890 | | 1561.0 | 1561.0 |
| 18 | Лүн | 3313 | 2816 | 66 | 2750 | 165.0 | 1485.0 | 1650.0 |
| 19 | Мөнгөнморьт | 4503 | 3827 | 26 | 3801 | 65.0 | 2053.0 | 2118.0 |
| 20 | Өндөрширээт | 2644 | 2247 | | 2247 | | 1213.3 | 1213.3 |
| 21 | **Сүмбэр** | **1960** | **1666** | **752** | **914** | **1880.0** | **1371.0** | **3251.0** |
| 22 | Сэргэлэн | 1421 | 1207 | | 1207 | | 652.0 | 652.0 |
| 23 | Угтаал | 2591 | 2202 | | 2202 | | 1189.0 | 1189.0 |
| 24 | Цээл | 2539 | 2158 | | 2158 | | 1165.0 | 1165.0 |
| 25 | Эрдэнэ | 6127 | 5207 | 14 | 5193 | 35.0 | 2804.2 | 2839.0 |
| 26 | Эрдэнэсант | 3613 | 3071 | | 3071 | | 1658.3 | 1658.0 |
| 27 | Зуунмод | 1360 | 1156 | 60 | 1096 | 150.0 | 592.0 | 742.0 |
| | **ДҮН** | **72976** | **52542** | **1810** | **34432** | **36220.0** | **18593.0** | **54813.0** |

Цэвэр болон эрлийз үнээнээс жилд саах сүүний хэмжээг 2000 л-ээр

Нутгийн үүлдрийн нэг үнээнээс өдөрт саах сүүг 3 л-ээр жилд 540 л-ээр тус тус тооцов.

## ТАЛ ХЭЭРИЙН СУМДЫН СҮҮНИЙ НӨӨЦ АШИГЛАЛТ

| д/д | Сумын нэр | Үнээний тоо /2010оны эцсийн тоогоор/ | Саалийн хугацаанд бэлтгэх нийт сүүний хэмжээ /мян.л/ | Дотоодын хэрэгцээнд бэлтгэх сүү /мян.л/ | Уламжлалт аргаар цагаан идээ боловсруулах сүүний хэмжээ /мян.л/ | Сүү боловсруулах тоног төхөөрөмжтэй болох сум |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | Архуст | 593 | 262.4 | 197.5 | 64.9 | **2013 онд** |
| 2 | Баян | 797 | 365.5 | 316 | 50 | **2013 онд** |
| 3. | Баянжаргалан | 1071 | 365.5 | 247 | 119 | **2013 онд** |
| 4. | Баян-Өнжүүл | 2338 | 1073.0 | 330 | 743 | **2011 онд** |
| 5. | Баянцагаан | 944 | 433.08 | 300 | 133 | **2012 онд** |
| 6. | Бүрэн | 2459 | 1128.6 | 474.7 | 654 | **2011 онд** |
| 7. | Дэлгэрхаан | 1048 | 480.6 | 263.2 | 217 | **2011 онд** |
| 8. | Өндөрширээт | 2644 | 1213.3 | 285.1 | 982 | **2012 онд** |
| 9. | Сэргэлэн | 1421 | 652.0 | 311.3 | 341 | **2012 онд** |

Нэг үнээнээс саах сүүний хэмжээг өдөрт 3 л, саалийн нийт хугацаанд 540 л-ээр тооцов.

## СҮҮ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН 2010 ҮЙЛДВЭРЛЭЛТИЙН ХЭМЖЭЭ

| № | Аж ахуйн нэгжийн нэр | Байгуулагдсан он | ХАА-гаас үйлдвэрт хүлээн авсан сүү | Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Тараг Мян.л | Цөцгий кг | Зөөхий кг | Аарц кг | Цөцгийн тос /кг/ | Бяслаг /кг/ | Ааруул /кг/ | Шар тос | Ариутгасан сүү /л/ |
| **1** | **2** | **3** | **4** | **5** | **6** | **7** | **8** | **9** | **10** | **11** | **12** | **14** |
| 1. | Хаан-Ембүү ХХК | 2009.08 сар | 1,2 мян.тн | 180.0 | 400 | 600 | 800 | | | | | |
| 2. | Лигийн –Ухаа ХХК | 1995 | 21 мян.л | | | | | | 1.8 | | | |
| 3. | АДФ ХХК | 2008 | 3 мян.л | | | | | | | | | |
| 4. | Шимт–Уринш ХХК | | 64 мян.л | 2.0 | | | 1000 | | | | | |
| 5. | Хад хөшиг ХХК | 2007 | 35 мян.л | 4.9 | 300 | | 200 | | | | | 21520 |
| 6. | Борнуур сум Бэрх–Оч ХХК | 2010 | 60 мян.л | 6.0 | 820 | | 380 | | | | | |
| 7. | Мөнгөнморьт Иргэн Энхбаяр | 2010 | 8.2 мян.л | 14.0 | | | | | | | | |
| 8. | Эрдэнэсант | 2010 | 4.5 мян.л | 1.8 | | | 450 | | | | | |
| 9. | Аргалант сум Жикс ХХК | 2010 | 120 мян.л | 5.0 | 1200 | | | | | | | |
| 10. | Борнуур сум Борнуур пүүдс ХХК | 2010 | 80 мян.л | 6.0 | | | | | | | | |
| | **Дүн** | | **3.2 мян.тн** | **217.6** | **2870** | **0,6** | **2630** | | **1.8** | | | |

## АЙМГИЙН СҮҮ ЦАГААН ИДЭЭ ҮЙЛДВЭРЛЭЛТ, БОРЛУУЛАЛТ, ХЭРЭГЛЭЭНИЙ СУДАЛГАА

| № | Үзүүлэлт | 2007он | 2008 он | 2009 он | 2010 он | 2009/2010 |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | Нийт хүн ам | 88828 | 88889 | 87210 | 87909 | 699 |
| | Аймгийн төвийн хүн | 14110 | 15264 | 15120 | 15295 | 175 |
| | Сумын төвийн хүн ам | 37737 | 37001 | 36846 | 36645 | -201 |
| 2. | Өрхийн тоо | 24960 | 25094 | 25060 | 25006 | -54 |
| 3. | Үүнээс: Малчин өрхийн тоо | 9246 | 9156 | 9125 | 9628 | 503 |
| 4. | Аймгийн төвийн зах зээлд нийлүүлсэн сүүний хэмжээ /сая.л/ | 2.2 | 2.4 | 3.1 | 2.8 | - 0.3 |
| 5. | Сүү цагаан идээний нэг хүний жилийн хэрэглээ /кг/ | | | | | |
| | Аймгийн төвд /нийслэлд/ кг | 74 | 89 | 91 | 98 | 7 |
| | Сумын төвд /дүүрэгт/кг | 131 | 124 | 138 | 146 | 8 |
| | Малчид хөдөөгийн иргэд /кг/ | 146 | 178 | 183,5 | 233 | 49.5 |
| | Сумын төвийн зах зээлд нийлүүлсэн сүүний хэмжээ /сая.л/ | 0.84 | 0.96 | 1.2 | 1.1 | -0.1 |
| 6. | УБ хотын боловсруулах үйлдвэрт нийлүүлсэн сүү /сая.л/ | 15 | 15.5 | 19 | 22.3 | 3.3 |
| 7. | Нийт боловсруулсан бүтээгдэхүүн | | | | | |
| | Ариутгасан сүү /мян.литр/ | 328 | 60 | 245 | 421 | 176 |
| | Тараг /мян.литр/ | 180 | 20 | 280 | 320 | 40 |
| | Цөцгий зөөхий /кг/ | 320 | 780 | 1200 | 1600 | 400 |
| | Цөцгийн тос /кг/ | 500 | 800 | 1300 | 800 | -400 |
| | Ааруц /кг/ | 8600 | 10400 | 17000 | 8500 | -8500 |
| | Ааруул /кг/ | 16000 | 21000 | 22800 | 1800 | -21000 |
| | Хуурай сүү /тн/ | - | - | - | | |
| | Бяслаг /тн/ | 2.1 | 2.5 | 2.3 | 1.8 | -0.5 |
| | Зайрмаг /мян.ширхэг / | - | - | - | | |
| | Айраг /тн/ | 831 | 895 | 987 | 310 | -677 |
| | Шар тос /кг/ | 860 | 910 | 1020 | 621 | |
| | Өрөм /кг/ | 1.5 | 1.9 | 2.2 | 1.6 | -0.6 |
| | Нийт борлуулсан бүтээгдэхүүн | | | | | |
| | Ааруул /тн/ | 1.2 | 2.1 | 2.4 | 1.8 | -0.6 |
| | Өрөм /тн/ | 0.6 | 0.6 | 0.5 | 0.2 | -0.3 |
| | Шар тос /тн/ | 0.3 | 0.45 | 0.6 | 0.3 | -0.3 |
| | Цөцгий, зөөхий /кг/ | 0.8 | 1580 | 2500 | 600 | -1900 |
| | Цөцгийн тос /тн/ | | | | | |
| | Айраг /тн/ | 25.8 | 26.2 | 27.6 | 20.3 | -7.3 |
| | Тараг /литр/ | 1260 | 2100 | 2800 | 2500 | -300 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Бусад | | | | | |
| **8.** | Сургуулийн хүүхдийн тоо | 15240 | 15387 | 15214 | 15100 | -114 |
| | Үүнээс 1-5–р ангийн | 6482 | 6500 | 6352 | 6302 | -51 |
| **9.** | Үдийн цай хөтөлбөрт хүлээн авсан | | | | | |
| | Сүү /литр/ | 1200 | 1800 | 2600 | 3600 | 1000 |
| | Тараг /литр/ | 340 | 600 | 1300 | 1000 | -300 |
| | Ааруц /кг/ | 1800 | 2400 | 3100 | 2500 | -600 |
| | Ааруул /кг/ | - | - | - | - | |
| | Бусад | | | | | |
| **10.** | Үдийн цай хөтөлбөрт нийлүүлсэн | | | | | |
| | Ариутгасан сүү /литр/ | 1200 | 1800 | 2200 | 7800 | 5600 |
| | Тараг /литр/ | 340 | 600 | 1100 | 900 | -200 |
| | Ааруц /литр/ | 1800 | 2400 | 2860 | 2700 | -160 |
| | Бусад | | | | | |
| | Үдийн цай хөтөлбөрт хамрагдаж сүү нийлүүлсэн өрхийн тоо | 37 | 41 | 46 | 64 | 18 |
| | Нийлүүлсэн сүүний хэмжээ /литр/ | 1200 | 1800 | 2600 | 2100 | -500 |
| | Тараг /литр/ | 340 | 600 | 1300 | 900 | -400 |
| | Ааруц | 1800 | 2400 | 3100 | 2700 | -400 |
| | Ааруул | - | - | - | | |
| | Бусад | | | | | |

# СҮҮНИЙ НӨӨЦ АШИГЛАЛТЫН МЭДЭЭ

| № | Үзүүлэлт | | 2007 | 2008 | 2009 | 2010 | 2009/2010 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Нийт малын тоо | | 2626541 | 3002955 | 3464172 | 2710709 | - 753463 |
| 2. | Саалинд хамрагдвал зохих | | 1150.5 | 1340519 | 1549366 | 994900 | - 554466 |
| 3. | Үүнээс | Ингэ | 631 | 793 | 902 | 461 | - 474 |
| | | Гүү | 63089 | 64470 | 70772 | 32499 | - 35605 |
| | | Үнээ | 61855 | 68877 | 78594 | 44824 | - 10191.8 |
| | | Хонь | 577746 | 677106 | 799546 | 452163 | - 255891 |
| | | Ямаа | 441207 | 529273 | 599552 | 290897 | - 226244 |
| 4. | Саалинд хамрагдсан | | 937474 | 1.0367 | 1286.8 | 845665 | - 441135 |
| | Үүнээс | Ингэ | 504 | 536 | 601 | 257 | - 344 |
| | | Гүү | 246751 | 254302 | 35105 | 21100 | - 14005 |
| | | Үнээ | 312550 | 51106.7 | 60910.3 | 44824 | - 16086.3 |
| | | Хонь | 208960 | 233201 | 311852 | 163096 | - 148756 |
| | | Ямаа | 168710 | 171820 | 240025 | 111992 | - 128033 |
| 5. | Саасан сүү /сая.л/ | | 40,6 | 42,7 | 46,7 | 33.8 | - 12.9 |
| | Үүнээс | Ингэ | 0,03 | 0,08 | 0,09 | 0.04 | - 0.05 |
| | | Гүү | 4,1 | 4,3 | 4,8 | 3.1 | - 1.7 |
| | | Үнээ | 36,8 | 38,1 | 41,3 | 22.3 | - 19 |
| | | Хонь | 0,1 | 0,2 | 0,3 | 0.1 | - 0.2 |
| | | Ямаа | 0,2 | 0,3 | 0,4 | 0.2 | - 0.2 |
| 6. | Сүүний чиглэлийн аж ахуй | | 131 | 141 | 181 | 188 | 7 |
| | Эрчимжсэн аж ахуйн үнээний тоо | | 1902 | 6500 | 7944 | 8074 | 130 |
| | Эрчимжсэн аж ахуйн нэг үнээнээс жилд саасан сүү | | 2400 | 2450 | 2500 | 2500 | |
| | Эрлийз үнээнээс жилд саасан сүү | | 1200 | 1250 | 1450 | 1500 | 50 |
| | Нутгийн үнээнээс | | 480 | 500 | 540 | 540 | |

## СҮҮНИЙ ЦЕХ, ҮЙЛДВЭРИЙН СУДАЛГАА

| Д/д | Сумын нэр | ААН-ийн нэр | Ашиглалтанд орсон | Бүтээгдэхүүний нэр төрөл | Тоног төхөөрөмж аль, улс | Хүчин чадал /өдөрт/ | | Хөрөнгө оруулалт | | | Ажилчдын тоо | Захирлын нэр утас |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Суурилагдсан | Ашиглаж буй % | Улс | Хувь | Бусад | | |
| **1** | **2** | **3** | **4** | **5** | **6** | **7** | **8** | **9** | **10** | **11** | **12** | **13** |
| **Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр, цехүүд** | | | | | | | | | | | | |
| 1. | Алтанбулаг | Лигийн-Ухаа ХХК | 1995 | Гоуда нэрийн бяслаг | Голланд | 10тн | 20% | | + | Төсөл | 8 | У.Төмөрхуяг 99184954 |
| 2. | Баянцогт | Шимт-Уринш ХХК | 2009 | Сүү , тараг цөцгий ариутган савлах | Монгол | 0,5-1,0тн | 30% | | | Сүү Хөт | 3 | Ганхуяг |
| 3. | Баянхангай | ЗДТГ | 2008 | Сүү, тараг | Монгол | 0,5 тн | ү/а яв/гүй | + | | | | ЗДТГ |
| 4. | Борнуур | Бэрх-Оч | 2009 | Сүү , тараг | Хятад | 1 тн | 2010 оноос | + | | | 3 | Б. Наранмөнх 99087387 |
| 5. | Борнуур | Борнуур пүүдс ХХК | 2009 | Сүү, тараг, хуурай сүү | Герман | 1 тн | 2010 оноос | | + | | 20 | Ч. Алтанхуяг |
| 6. | Батсүмбэр | ЗДТГ | 2007 | Сүү | Монгол | 0,5 тн | ү/а яв/гүй | + | | | | ЗДТГ |
| 7. | Лүн | АДФ ХХК | 2008 | Сүү, тараг | Монгол | 0,5 тн | 30% | + | | | 3 | Д.Даваадорж |
| 8. | Жаргалант | Хад хөшиг ХХК | 2007 | Сүү, тараг | | 1 тн | 30% | | | Сүү хөт | 3 | Б.Баттулга 99890365 |
| 9. | Жаргалант | Хаан-Ембүү ХХК | 2009 | Сүү, тараг, цөцгий, масло | Чех | 5-10тн | 50% | | + | | 50 | Мөнхжаргал 99081678 |
| 10. | Сүмбэр | Иргэн А.Бадамлхагва | 2009 | Сүү, тараг ариутган савлах | Монгол | 0,5-1 тн | 2010 оноос | + | | | 3 | А.Бадамлхагва 99246815 |
| 11. | Эрдэнэ | Агрико-Эрдэнэ ХХК | 2007 | Сүү, тараг ариутган савлах | БНХАУ | 1 тн | Аж/гүй | | + | | 6 | Ш.Энх-Од |
| 12. | Мөнгөнморьт | Иргэн Энхбаяр | 2010 | Сүү, сүүн бүтээгдэхүүн | Монгол | 0.5 тн | 30% | | + | | 8 | Н.Энхбаяр |
| 13. | Эрдэнэсант | Ундрах-Сүндэх ХХК | 2010 | Сүү, сүүн бүтээгдэхүүн | Хятад | 0,.5 | 30 | | + | + | 3 | Б.Буянхишиг |
| 14. | Дэлгэрхаан | Скайброс ХХК | 2010 | Сүү, сүүн бүтээгдэхүүн | Хятад | 0.5 | | + | | | | ЗДТГ |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 15. | Баянчандмань | Мон таримал ХХК | 2010 | Сүү,сүүн бүтээгдэхүүн | Энэтхэг | Өдөрт 5 тн | Аж/гүй | | Төсөл 40% | | 5 | Р. Цогтбуян |
| 16. | Аргалант | Жикс ХХК | 2010 | Сүү,сүүн бүтээгдэхүүн | Энэтхэг | Өдөрт 5 тн | Аж/гүй | | Төсөл 40% | | 5 | Сүхбаатар |

## СҮҮНИЙ НӨӨЦ, ХЭРЭГЦЭЭ, ХЭРЭГЛЭЭНИЙ СУДАЛГАА

| | **Сумын нэр** | **Нийт сүүний нөөц** | **Хүн амын тоо** | **Сумын нийт хэрэгцээ /мян.л/** | **Үүнээс** | | | | | | | **Зах зээлд нийлүүлэх сүү / мян.л/** |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **Дотуур байрны хүүхдийн тоо** | **Сүү цагаан идээний хэрэгцээ /тн/** | **СӨБ-ын хүүхдийн тоо** | **Сүү цагаан идээний хэрэгцээ / тн/** | **Эмнэлэгт хэвтэн эмчлүүл/н тоо** | **Сүү цагаан идээний хэрэгцээ /тн/** | **Өрхийн хэрэгцээнд /мян.л/** | |
| 1. | Алтанбулаг | 1430.0 | 2918 | 458.1 | 92 | 10.6 | 119 | 13.8 | 425 | 1.8 | 432.0 | 972.0 |
| 2. | Аргалант | 1298.0 | 1585 | 248.8 | 122 | 14.1 | 70 | 8.1 | 345 | 1.5 | 225.1 | 1049.2 |
| 3 | Архуст | 307.0 | 1258 | 189.0 | 19 | 2.2 | 67 | 7.7 | 136 | 0.6 | 178.5 | 118.0 |
| 4 | **Батсүмбэр** | **13915.0** | 6753 | 904.0 | 318 | 36.8 | 90 | 10.4 | 701 | 3.0 | 853.8 | 13011.0 |
| 5 | Баян | 365.5 | 2011 | 292.0 | 29 | 3.3 | 75 | 8.7 | 281 | 1.2 | 278.8 | 73.5 |
| 9 | Баянхангай | 700.0 | 1427 | 203.2 | 96 | 11.1 | 126 | 14.6 | 295 | 1.2 | 176.3 | 496.8 |
| 10 | Баянцагаан | 433.08 | 1912 | 294.5 | 78 | 9.0 | 220 | 25.5 | 223 | 1.0 | 259.0 | 138.5 |
| 11 | Баянцогт | 1146.0 | 1880 | 285.8 | 76 | 8.8 | 112 | 13.0 | 304 | 1.3 | 262.7 | 860.2 |
| 12 | **Баянчандмань** | **5125.0** | 3730 | 534.0 | 80 | 9.2 | 412 | 47.7 | 422 | 1.8 | 475.3 | 4591.0 |
| 13 | **Борнуур** | **7636.5** | 4817 | 658.0 | 159 | 18.4 | 187 | 21.6 | 504 | 2.1 | 616.0 | 6979.0 |
| 14 | Бүрэн | 1128.6 | 3024 | 430.0 | 80 | 9.2 | 170 | 19.7 | 232 | 1.0 | 400.0 | 798.6 |
| 15 | Дэлгэрхаан | 480.6 | 1677 | 270.4 | 113 | 13.1 | 144 | 16.7 | 292 | 1.2 | 239.4 | 210.2 |
| 16 | **Жаргалант** | **5378.0** | 6223 | 841.1 | 169 | 19.6 | 315 | 36.5 | 707 | 3.0 | 782.0 | 4537.0 |
| 17 | Заамар | 1561.0 | 5084 | 828.0 | 195 | 22.6 | 410 | 47.5 | 658 | 2.8 | 755.1 | 733.0 |
| 18 | Лүн | 1650.0 | 2604 | 350.0 | 98 | 11.3 | 155 | 18.0 | 417 | 1.7 | 319.0 | 1300.0 |
| 19 | Мөнгөнморьт | 2118.0 | 2083 | 272.2 | 77 | 9.0 | 131 | 15.1 | 318 | 1.3 | 246.6 | 1846.0 |
| 20 | Өндөрширээт | 1213.3 | 1816 | 279.1 | 54 | 6.2 | 107 | 12.4 | 421 | 1.7 | 258.8 | 933.9 |
| 21 | **Сүмбэр** | **3251.0** | 1708 | 240.0 | 73 | 8.4 | 106 | 12.4 | 283 | 1.2 | 218.0 | 3011.0 |
| 22 | Сэргэлэн | 652.0 | 1983 | 266.2 | 17 | 2.0 | 126 | 14.6 | 123 | 0.5 | 249.1 | 385.8 |
| 23 | Угтаал | 1189.0 | 2411 | 320.2 | 118 | 13.6 | 167 | 19.3 | 315 | 1.3 | 286.0 | 868.8 |
| 24 | Цээл | 1165.0 | 2479 | 338.0 | 105 | 12.1 | 153 | 17.7 | 458 | 2.0 | 306.0 | 827.0 |
| 25 | Эрдэнэ | 2839.0 | 3791 | 497.0 | 267 | 31.0 | 254 | 29.4 | 334 | 1.4 | 435.2 | 2342.0 |
| 26 | Эрдэнэсант | 1658.0 | 4470 | 645.0 | 155 | 18.0 | 240 | 27.8 | 409 | 1.7 | 597.5 | 1013.0 |
| 27 | Зуунмод | 742.0 | 15295 | 2401.3 | 201 | 23.3 | 1066 | 123.6 | 6512 | 28.0 | 567.1 | -1659.0 |
| | **ДҮН** | **54813.0** | **87909** | **12656.0** | **2970** | **345.0** | **5538** | **642.4** | **15979** | **69.0** | **12656.0** | **42157.0** |

## СҮҮНИЙ НӨӨЦ, ХЭРЭГЦЭЭ, ХЭРЭГЛЭЭНИЙ СУДАЛГАА

| | Сумын нэр | Нийт сүүний нөөц | Хүн амын тоо | Сумын нийт хэрэгцээ /мян.л/ | 2010 | | | | | | | Зах зээлд нийлүүлэх сүүний хэмжээ /мян.л/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Дотуур байрны хүүхдийн тоо | Сүү цагаан идээний хэрэгцээ /тн/ | СӨБ-ын хүүхдийн тоо | Сүү цагаан идээний хэрэгцээ /тн/ | Эмнэлэгт хэвтэн эмчл /н тоо | Сүү цагаан идээний хэрэгцээ /тн/ | Өрхийн хэрэгцээнд /мян.л/ | |
| 1. | Алтанбулаг | 1230.0 | 2918 | 458.1 | 92 | 10.6 | 119 | 13.8 | 425 | 1.8 | 432.0 | 972.0 |
| 2. | Аргалант | 1198.0 | 1585 | 248.8 | 122 | 14.1 | 70 | 8.1 | 345 | 1.5 | 225.1 | 1049.2 |
| 3 | Архуст | 307.0 | 1258 | 189.0 | 19 | 2.2 | 67 | 7.7 | 136 | 0.6 | 178.5 | 118.0 |
| 4 | **Батсүмбэр** | **13915.0** | 6753 | 904.0 | 318 | 36.8 | 90 | 10.4 | 701 | 3.0 | 853.8 | 13011.0 |
| 5 | Баян | 365.5 | 2011 | 292.0 | 29 | 3.3 | 75 | 8.7 | 281 | 1.2 | 278.8 | 73.5 |
| 6 | Баяндэлгэр | 903.2 | 1292 | 164.0 | 39 | 4.5 | 97 | 11.2 | 253 | 1.0 | 157.3 | 939.0 |
| 7 | Баянжаргалан | 491.4 | 1575 | 225.6 | 72 | 8.3 | 88 | 10.2 | 285 | 1.2 | 215.9 | 265.8 |
| 8 | Баян-Өнжүүл | 1073.0 | 2103 | 327.4 | 67 | 7.7 | 139 | 16.1 | 311 | 1.3 | 302.3 | 745.6 |
| 9 | Баянхангай | 700.0 | 1427 | 203.2 | 96 | 11.1 | 126 | 14.6 | 295 | 1.2 | 176.3 | 496.8 |
| 10 | Баянцагаан | 433.08 | 1912 | 294.5 | 78 | 9.0 | 220 | 25.5 | 223 | 1.0 | 259.0 | 138.5 |
| 11 | Баянцогт | 1046.0 | 1880 | 285.8 | 76 | 8.8 | 112 | 13.0 | 304 | 1.3 | 262.7 | 860.2 |
| 12 | **Баянчандмань** | **5125.0** | 3730 | 534.0 | 80 | 9.2 | 412 | 47.7 | 422 | 1.8 | 475.3 | 4591.0 |
| 13 | **Борнуур** | **7636.5** | 4817 | 658.0 | 159 | 18.4 | 187 | 21.6 | 504 | 2.1 | 616.0 | 6979.0 |
| 14 | Бүрэн | 1028.6 | 3024 | 430.0 | 80 | 9.2 | 170 | 19.7 | 232 | 1.0 | 400.0 | 798.6 |
| 15 | Дэлгэрхаан | 480.6 | 1677 | 270.4 | 113 | 13.1 | 144 | 16.7 | 292 | 1.2 | 239.4 | 210.2 |
| 16 | **Жаргалант** | **5378.0** | 6223 | 841.1 | 169 | 19.6 | 315 | 36.5 | 707 | 3.0 | 782.0 | 4537.0 |
| 17 | Заамар | 1061.0 | 5084 | 828.0 | 195 | 22.6 | 410 | 47.5 | 658 | 2.8 | 755.1 | 733.0 |
| 18 | Лүн | 1150.0 | 2604 | 350.0 | 98 | 11.3 | 155 | 18.0 | 417 | 1.7 | 319.0 | 1300.0 |
| 19 | Мөнгөнморьт | 1918.0 | 2083 | 272.2 | 77 | 9.0 | 131 | 15.1 | 318 | 1.3 | 246.6 | 1846.0 |
| 20 | Өндөрширээт | 1013.3 | 1816 | 279.1 | 54 | 6.2 | 107 | 12.4 | 421 | 1.7 | 258.8 | 933.9 |
| 21 | **Сүмбэр** | **3251.0** | 1708 | 240.0 | 73 | 8.4 | 106 | 12.4 | 283 | 1.2 | 218.0 | 3011.0 |
| 22 | Сэргэлэн | 552.0 | 1983 | 266.2 | 17 | 2.0 | 126 | 14.6 | 123 | 0.5 | 249.1 | 385.8 |
| 23 | Угтаал | 1030.0 | 2411 | 320.2 | 118 | 13.6 | 167 | 19.3 | 315 | 1.3 | 286.0 | 868.8 |
| 24 | Цээл | 1165.0 | 2479 | 338.0 | 105 | 12.1 | 153 | 17.7 | 458 | 2.0 | 306.0 | 827.0 |
| 25 | Эрдэнэ | 1839.0 | 3791 | 497.0 | 267 | 31.0 | 254 | 29.4 | 334 | 1.4 | 435.2 | 2342.0 |
| 26 | Эрдэнэсант | 1158.0 | 4470 | 645.0 | 155 | 18.0 | 240 | 27.8 | 409 | 1.7 | 597.5 | 1013.0 |
| 27 | Зуунмод | 742.0 | 15295 | 2401.3 | 201 | 23.3 | 1066 | 123.6 | 6512 | 28.0 | 567.1 | -1659.0 |
| | **ДҮН** | **54813.0** | **87909** | **12656000** | **2970** | **345.0** | **5538** | **642.4** | **15979** | **69.0** | **12656.0** | **42157.0** |

## СҮҮНИЙ НӨӨЦ, ҮЙЛДВЭРЛЭХ, БОЛОВСРУУЛАХ СҮҮНИЙ ХЭМЖЭЭ /2016 ОН ХҮРТЭЛ/

| № | Үзүүлэлтүүд | 2011 он | | 2012 он | | 2013 он | | 2014 он | | 2015 он | | 2016 он | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | **Тоо** | **Саах сүүний хэмжээ /мян.литр/** | **Тоо** | **Саах сүүний хэмжээ /мян.литр/** | **Тоо** | **Саах сүүний хэмжээ /мян.литр/** | **Тоо** | **Саах сүүний хэмжээ /мян.литр/** | **Тоо** | **Саах сүүний хэмжээ /мян.литр/** | **Тоо** | **Саах сүүний хэмжээ /мян.литр/** |
| | Саалинд хамрагдах нийт үнээ | 52542 | 54813.0 | 56426 | 60210.2 | 61756 | 65461.0 | 67961 | 73841.0 | 73412 | 79923.8 | 76757 | 84250.1 |
| **Үүнээс** | Цэвэр, эрлийз үнээний тоо | 18110 | 36220.0 | 20370 | 40740.0 | 22680 | 45360.0 | 25440 | 50880.0 | 27590 | 55180.0 | 29316 | 58632.0 |
| | Нутгийн үүлдрийн үнээ | 34432 | 18593.0 | 36056 | 19470.2 | 39076 | 21101.0 | 42521 | 22961.3 | 45822 | 24743.8 | 47441 | 25618.1 |
| **Жилд саах сүү /дунджаар/** | Цэвэр, эрлийз үнээнээс | | 2.0 | | 2.0 | | 2.0 | | 2.0 | | 2.0 | | 2.0 |
| | Нутгийн үүлдрийн үнээнээс | | 0.54 | | 0.54 | | 0.54 | | 0.54 | | 0.54 | | 0.54 |
| | Үйлдвэрийн аргаар боловсруулах сүү сүүн бүтээгдэхүүний хэмжээ | 5 мян.тн | | 7 мян.тн | | 10 мян.тн | | 13 мян.тн | | 15 мян.тн | | 17 мян.тн | |
| **Уламжлалт аргаар** | Цөцгийн тос | 3 тн | 66,0 | 5 тн | 110.0 | 8 тн | 176 | 10 тн | 220.0 | 12 тн | 264 | 15 тн | 330 |
| | Ааруул | 24 тн | 216 | 30 тн | 270 | 36 тн | 324 | 40 тн | 360 | 45 тн | 405 | 50 тн | 450 |
| | Аарц | 528тн | 3168.0 | 600 тн | 3600.0 | 670 тн | 4020.0 | 700 тн | 4200.0 | 780 тн | 4680.0 | 800 тн | 4800.0 |
| | Ээзгий | 4.6 тн | 50.6 | 5.2 тн | 57.2 | 5.4 тн | 59.4 | 5.6 тн | 61.6 | 5.8 тн | 63.8 | 6 тн | 66.0 |
| | Өрөм | 1.2 тн | 24.9 | 1.5 тн | 31.2 | 1.8 тн | 37.4 | 2 тн | 41.6 | 2.3 тн | 47.8 | 2.5 тн | 52.0 |

## СҮҮНИЙ НӨӨЦ, ХЭРЭГЦЭЭ, ХЭРЭГЛЭЭНИЙ СУДАЛГАА /2011 ОНЫ БАЙДЛААР/

| | Сумын нэр | Нийт сүүний нөөц | Хүн амын тоо | Сумын нийт хэрэгцээ /мян.л/ | Үүнээс | | | | | | | Зах зээлд нийлүүлэх сүү /мян.л/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Дотуур байрны хүүхдийн тоо | Сүү цагаан идээний хэрэгцээ /тн/ | СӨБ-ын хүүхдийн тоо | Сүү цагаан идээний хэрэгцээ /тн/ | Эмнэлэгт хэвтэн эмчлүүл/н тоо | Сүү цагаан идээний хэрэгцээ /тн/ | Өрхийн хэрэгцээнд /мян.л/ | |
| **1.** | Алтанбулаг | 1430.0 | 2918 | 458.1 | 92 | 10.6 | 119 | 13.8 | 425 | 1.8 | 432.0 | 972.0 |
| **2.** | Аргалант | 1298.0 | 1585 | 248.8 | 122 | 14.1 | 70 | 8.1 | 345 | 1.5 | 225.1 | 1049.2 |
| **3** | Архуст | 307.0 | 1258 | 189.0 | 19 | 2.2 | 67 | 7.7 | 136 | 0.6 | 178.5 | 118.0 |
| **4** | **Батсүмбэр** | **13915.0** | 6753 | 904.0 | 318 | 36.8 | 90 | 10.4 | 701 | 3.0 | 853.8 | 13011.0 |
| **5** | Баян | 365.5 | 2011 | 292.0 | 29 | 3.3 | 75 | 8.7 | 281 | 1.2 | 278.8 | 73.5 |
| **6** | Баяндэлгэр | 1103.2 | 1292 | 164.0 | 39 | 4.5 | 97 | 11.2 | 253 | 1.0 | 157.3 | 939.0 |
| **7** | Баянжаргалан | 491.4 | 1575 | 225.6 | 72 | 8.3 | 88 | 10.2 | 285 | 1.2 | 215.9 | 265.8 |
| **8** | Баян-Өнжүүл | 1073.0 | 2103 | 327.4 | 67 | 7.7 | 139 | 16.1 | 311 | 1.3 | 302.3 | 745.6 |
